

ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2026 оны 03 сарын 31 өдөр

Дугаар А/52

Улаанбаатар хот

Халдварын сэргийлэлт, хяналтын орон тооны
бус алба, багийн бүрэлдэхүүн, чиг үүргийг
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 8.3 дахь, Монгол Улсын Эрүүл мэндийн сайдын 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/536 тоот тушаалыг хэрэгжүүлэх, ЭХЭМҮТ-д халдварын сэргийлэлт, хяналтын тогтолцоог эрчимжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. ЭХЭМҮТ-ийн халдварын сэргийлэлт, хяналтын үйл ажиллагааны дүрмийг нэгдүгээр, төвийн хэмжээнд эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх, хянах асуудлыг хариуцан ажиллах чиг үүрэг бүхий Халдварын сэргийлэлт, хяналтын орон тооны бус албаны бүрэлдэхүүн, чиг үүргийг хоёрдугаар, Халдварын сэргийлэлт, хяналтын орон тооны бус багийн бүрэлдэхүүн, чиг үүргийг гуравдугаар, халдварын сэргийлэлт, хяналтын чиглэлээр хийгдэх үйл ажиллагааны жагсаалтыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.
2. Тушаалын хэрэгжилтийг хангаж, төвийн хэмжээнд эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх, хянах, журам, зааврын хэрэгжүүлж, эрсдэлийг бууруулж ажиллахыг энэхүү тушаалаар байгуулагдсан орон тооны бус алба, багийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.
3. Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/536 дугаар тушаалд заасныг үндэслэн тасаг бүр Халдварын сэргийлэлт, хяналтын багийг томилон, хийсэн ажлаа улирал бүр хэлэлцэн, тайланг эмнэлгийн Халдварын сэргийлэлт, хяналтын орон тооны бус багт хүргүүлэн ажиллахыг халдварын сэргийлэлт, хяналтын багийн дарга нарт үүрэг болгосугай.
4. Төвийн халдварын сэргийлэлт хяналтын орон тооны бус алба, багийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүй, удирдлагаар хангаж ажиллахыг Халдварын сэргийлэлт, хяналтын орон тооны бус албаны нарийн бичгийн дарга /Б.Отгончимэг/-д үүрэг болгосугай.
5. ЭХЭМҮТ-ийн хэмжээнд халдварын сэргийлэлт, хяналтын тогтолцоог сайжруулах, эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх үйл ажиллагаа, сургалт, хангамж үйлчилгээнд шаардлагатай хөрөнгийг тусгайлан тооцоолж, жил бүрийн төсөвт тусган ажиллахыг Үйл ажиллагаа, төлөвлөлт хариуцсан дэд захирал /Э.Бямбасүрэн/-д даалгасугай.
6. Энэхүү тушаалыг 2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөн ажиллахыг эмнэлэг, тасаг, нэгжийн дарга нарт даалгасугай.
7. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг төвийн Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албаны дарга /А.Оюунчимэг/-д даалгасугай.
8. Уг тушаал гарсантай холбогдуулан төвийн Захирлын 2019 оны А/156 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

ЗАХИРАЛ  Ж.ОТГОНБААТАР



1606060308

Захирлын 2026 онысарынөдрийн
.....тоот тушаалын-р хавсралт

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн халдварын
сэргийлэлт хяналтын үйл ажиллагааны дүрэм

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү дүрмийг ЭХЭМҮТ-ийн бүх тасаг нэгж мөрдөж ажиллана.
- 1.2. Халдварын сэргийлэлт, хяналт (цаашид ХСХ гэх) нь эрүүл мэндийн байгууллагын ажиллагсад, үйлчлүүлэгч, тэдний гэр бүл болон бусад иргэд эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдварт өртөхөөс урьдчилан сэргийлэх, хяналт тавих үйл ажиллагааны хэм хэмжээ юм.
- 1.3. Эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдвар (цаашид ЭТҮХХ гэх) гэдэг нь эрүүл мэндийн байгууллагад хийгдсэн эмчилгээ, үйлчилгээний явцад үйлчлүүлэгч шинээр халдвар авч халдварын шинж тэмдэг нь эмнэлэгт хэвтсэнээс хойш 24 цаг ба түүнээс хойших хугацаанд, эмнэлгээс гарсны дараах 1 сар, эрхтэн шилжүүлэн суулгах, хиймэл эд эрхтэн суулгах ажилбарын дараах 1 жил хүртэл хугацаанд илэрсэн халдвар, эрүүл мэндийн ажилтан ажил үүргээ гүйцэтгэж байх явцад халдварт өртөх тохиолдол юм.
- 1.4. ХСХ-ын тогтолцооны зорилго нь ЭТҮХХ-аас сэргийлэх, тохиолдлыг эрт илрүүлж хариу арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэх замаар үйлчлүүлэгчдэд аюулгүй, чанартай тусламж, үйлчилгээ үзүүлэхэд оршино.
- 1.5. Төв нь өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон ЭТҮХХ, ХСХ-ын хөтөлбөр, төлөвлөгөөтэй ажиллана.
- 1.6. ХСХ-д шаардагдах санхүүжилтийг жил бүр байгууллагын улсын төсөвт тусган шийдвэрлэнэ.
- 1.7. ЭХЭМҮТ-ийн хэмжээнд ЭТҮХХ-ын эрсдэлийг бууруулах, сэргийлэх, хянахад нэгдмэл байдлаар буюу бүх хүний оролцоог ханган ажиллана.
- 1.8. Эрүүл мэндийн тухай хуульд заасан байгууллагын төрөл, үзүүлж буй тусламж, үйлчилгээ, түүний эрсдлээс хамаарч, тархвар/халдвар судлаач, халдварын сэргийлэлт, хяналтын эмч, халдварын сэргийлэлт, хяналтын сувилагчтай байна.
- 1.9. Төвийн тусламж үйлчилгээнд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл багаж, тоног төхөөрөмж, хамгаалах хувцас, хэрэгсэл, улсын бүртгэлд бүртгэгдсэн эрүүл мэндийн байгууллагад хэрэглэх зориулалт бүхий чанарын шаардлага хангасан ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис, ариун цэврийн бүтээгдэхүүн зэргийн тооцоог гаргаж, тасралтгүй хангана.
- 1.10. Төвийн барилга, байгууламжийн орчинд хортон шавж, мэрэгч үүрлэх, тархахаас урьдчилан сэргийлж ахуйн шавж, мэрэгч устгал, халдваргүйжүүлэлтийг жилд нэгээс хоёр удаа, шавж мэрэгч үүрлэсэн тохиолдол бүрд мэргэжлийн байгууллагаар устгал хийлгэнэ.
- 1.11. Төвийн эмч, ажилчдыг жил бүр эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах, шаардлагатай тохиолдолд эмчлэх, эрүүлжүүлэх асуудлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулна.
- 1.12. ЭХЭМҮТ-ийн ХАБЭА хариуцсан мэргэжилтэн нь "Ажлын байрны аюулгүй байдал, ажилтны эрүүл мэнд" хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлнэ.
- 1.13. Олон улсын эрүүл мэндийн дүрмээр зохицуулагдах халдварт өвчнөөс эрүүл мэндийн ажилтнуудыг хамгаалах, уг халдвар илэрсэн тохиолдолд авах арга хэмжээний талаар сургалт, сурталчилгаа зохион байгуулж, мэдлэг дадал олгосон байна.

1.14. Эрүүл мэндийн ажилтныг халдвараас сэргийлэх зорилгоор дархлаажуулах ажлыг зохион байгуулж, дархлаажуулалтын талаар нэгдсэн бүртгэл судалгаатай байна.

1.15. Ажил олгогч нь эрүүл мэндийн ажилтныг ажлын байранд гарахын өмнө халдварын сэргийлэлт, хяналтын сургалтад хамруулж, мэргэжлийн эрсдэлт хүчин зүйлсийн талаар санамж, зөвлөгөө өгч, хөдөлмөрийн гэрээнд тусгасан байна.


1.16. Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэргэжлийн эрсдэлт хүчин зүйлсийг судлан тогтоож, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, халдварт өртсөн байж болох тохиолдолд эрсдлийг үнэлэн, шаталсан арга хэмжээ хэрхэн авах талаарх мэдээллээр ажилтнуудыг бүрэн хангана.

1.17. Халдвараас сэргийлэх дэглэмийг чанд баримтлан цэвэр орчинд, ариун багаж хэрэгслээр үйлчлүүлэгчид эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлнэ.

1.18. Шинэ ажилтанд ХСХ-ын чиглэлээр эмнэлэгт мөрдөх журам, зааврыг таниулах баримжаа олгох сургалтыг ажилд орохоос өмнө хийнэ.

2.4.2. Эрүүл мэндийн ажилтны ХСХ-ын мэдлэг, дадлыг сайжруулах сургалт, сурталчилгаа, аян, мэдээлэл өгөх ажлыг жил бүр тасралтгүй зохион байгуулна.

Захирлын 2026 оны ...сарын ...өдрийн
...тоот тушаалын ...-р хавсралт



ЭХЭМҮТ-ийн ХСХ-ын орон тооны бус албаны бүтэц, хийх
ажлын чиглэл

Дарга:	ЭХЭМҮТ-ийн захирал
Нарийн бичгийн дарга:	АХТ-ийн эрхлэгч, тархвар судлаач эмч
Гишүүд:	Эмчилгээ эрхэлсэн дэд захирлууд /ЭБЭЭ, ХЭ/ Хүний нөөцийн албаны дарга ҮАТ-т эрхэлсэн дэд захирал ЭМТҮЧАБЭА-ны дарга Сувилахуй эрхэлсэн дэд захирал Эм зүйн албаны дарга Тандалт, судалгаа, статистикийн албаны дарга Нэгдсэн лабораторийн тасгийн эрхлэгч ЭТТТ-ийн албаны дарга Тархвар судлаач эмч нар ХҮИТХҮ-н албаны дарга ЭЗДА-ны дарга ХАБЭА хариуцсан мэргэжилтэн

Халдварын сэргийлэлт, хяналтын орон тооны бус албаны үүрэг, ажлын чиглэл

1. Халдварын сэргийлэлт, хяналтын чиглэлээрх журам, зааврын хэрэгжилтийг хангаж эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдвар (ЭТҮХХ)-аас сэргийлэх, эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг удирдан зохион байгуулж ажиллах
2. Эмнэлэг бүрд ХСХ-ын орон тооны бус багийг эмчилгээ эрхэлсэн дэд захирлаар ахлуулан ажиллуулж, халдварын сэргийлэлт хяналтын орон тооны бус баг, тасаг нэгж дэх халдварын сэргийлэлт хяналтын багийн үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр хангах
3. ЭТҮХХ-ын эрсдэлийг бууруулах, сэргийлэх, хянахад нэгдмэл байдлаар буюу бүх хүний оролцоог ханган ажиллах
4. Тасаг нэгж бүрд ХСХ-ын асуудал хариуцсан ажилтанг томилж, давхар ажил гүйцэтгэж байгаа бол ажлын цагийн зохицуулалт хийх
5. Байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэх ХСХ-ын хөтөлбөр, жил бүрийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг гаргаж, хэрэгжилтэд хяналт тавих
6. ХСХ-ын үйл ажиллагаанд шаардагдах санхүүжилтийг жил бүрийн улсын төсөвт тусган шийдвэрлэх
7. Албаны хурлыг улиралд нэг удаа, шаардлагатай тохиолдолд тухай бүр хийж ХСХ-ын чиглэлээр гүйцэтгэж буй ажил, тулгамдсан асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх
8. ЭТҮХХ-ын дэгдэлт гарсан үед хариу арга хэмжээг удирдан зохион байгуулж, эмнэлгийн чадамж хүрэхгүй тохиолдолд холбогдох мэргэжлийн байгууллагаас туслалцаа авч ажиллах
9. ЭТҮХХ-ын тохиолдлыг лабораторийн шинжилгээгээр баталгаажуулах, урвалж оношлуураар хангах асуудлыг хариуцах
10. Бичил биетний тэсвэржилттэй уялдуулан бичил биетний эсрэг эм, бэлдмэлийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх
11. Олон улсын эрүүл мэндийн дүрмээр зохицуулагддаг халдварт өвчин болон олон хүнийг хамарсан халдварт өвчин гарсан үед удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах
12. Эрүүл мэндийн ажилтныг халдварт өртөх эрсдэлээс сэргийлэх, хамгаалах хувцас хэрэгслээр хангах арга хэмжээг хэрэгжүүлэх
13. Халдвараас сэргийлэх дэглэмийн зөрчил, алдаа дутагдлыг бүртгэж, арилгуулах арга хэмжээг авах
14. Өөрсдийн санаачлагаар ХСХ-ын үйл ажиллагааг сайжруулахад оролцож ажиллах сонирхолтой сайн дурын ажилтан, мэргэжилтний санал, санаачлагыг дэмжиж, байгууллагын дотоод журмаар зохицуулан ажиллах

15. ХСХ-ын чиглэлээр амжилт гаргасан, дэмжлэг үзүүлсэн байгууллага, тасаг, нэгж, эмнэлгийн ажилтнуудын үйл ажиллагаа, туршлагыг сурталчилж, урамшуулах
16. Цусаар дамжих халдвартай эрүүл мэндийн ажилтны эрүүл мэндийн байдалд жил бүр хяналт тавьж, вирусийн идэвхжлийг хянаж, халдвараас сэргийлэх арга хэмжээний талаар хөдөлмөрийн гэрээнд тусган, заавар зөвлөгөө өгөх
17. Эрүүл мэндийн ажилчдыг халдвараас сэргийлэх зорилгоор дархлаажуулалтын ажлыг зохион байгуулж, ВГВ-ийн вакцины дараах дархлаа тогтоцын шинжилгээнд хамруулах
18. Эрүүл мэндийн ажилчдын цусаар дамжих халдварын эрсдэлд өртсөн тохиолдлыг бүртгэн, ӨДС-ийн хариу арга хэмжээг авч ажиллах
19. ХСХ-ын үйл ажиллагаанд шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, хүний нөөцийн хангалт, сургах, чадавхижуулах асуудлыг хариуцах;
20. Шаардлагатай тохиолдолд эмнэлгийн хэмжээнд ХСХ-ын үйл ажиллагаанд хяналт үнэлгээ хийх

Захирлын 2026 онысарынөдрийн
.....тоот тушаалын-р хавсралт

ЭХЭМҮТ-ийн Эх барих, эмэгтэйчүүдийн эмнэлэг /ЭБЭЭ/-ийн халдварын сэргийлэлт, хяналтын орон тооны бус багийн бүрэлдэхүүн

Дарга: ЭХЭМҮТ-ийн Эх, барих эмэгтэйчүүдийн эмнэлзүй эрхэлсэн дэд захирал
Нарийн бичгийн дарга: ЭБЭЭ-ийг хариуцсан тархвар судлаач эмч
Гишүүд: ЭБЭЭ-ийн чанарын менежер
ЭБЭЭ-ийн тусламж үйлчилгээ хариуцсан зохицуулагч
ЭБЭЭ-ийг хариуцсан сувилахуйн арга зүйч нар
ЭБЭЭ-ийн тасгийн эрхлэгч нар
ЭБЭЭ-ийг хариуцсан эмнэлзүйн эмзүйч
ЭБЭЭ-ийн хангамж үйлчилгээний зохицуулагч
Нян судлаач эмч

ЭХЭМҮТ-ийн Хүүхдийн эмнэлэг /ХЭ/-ийн халдварын сэргийлэлт, хяналтын орон тооны бус багийн бүрэлдэхүүн

Дарга: ЭХЭМҮТ-ийн Хүүхдийн эмнэлзүй эрхэлсэн дэд захирал
Нарийн бичгийн дарга: ХЭ-ийг хариуцсан тархвар судлаач эмч
Гишүүд: ХЭ-ийн чанарын менежерүүд
ХЭ-ийн тусламж үйлчилгээ хариуцсан зохицуулагч
ХЭ-ийг хариуцсан сувилахуйн арга зүйч нар
ХЭ-ийн тасгийн эрхлэгч нар
ХЭ-ийг хариуцсан эмнэлзүйн эмзүйч
ХЭ-ийн хангамж үйлчилгээний зохицуулагч
Нян судлаач эмч

ЭХЭМҮТ-ийн халдвар хяналтын орон тооны бус багуудын хийх ажлын чиглэл

- Эмнэлэг бүр халдварын сэргийлэлт, хяналтын чиглэлээр хийх ажлын төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах
- Төлөвлөгөөний биелэлтийг улирал бүр хэлэлцэн, хийсэн ажлын тайланг төвийн халдварын сэргийлэлт, хяналт /ХСХ/-ын албанд хүргүүлэх
- Эмнэлгүүдийн тасаг бүрт 3-5 хүний бүрэлдэхүүнтэй ХСХ-ын дэд багийг томилон ажиллуулж, хийх ажлын нэгдсэн төлөвлөгөөтэй байх
- Тасгийн ахлах сувилагчийг тасгийн халдвар хяналтын ажилтнаар томилон ажиллуулж, сургаж дадлагажуулах
- Эмнэлгийн ХСХ-ын үйл ажиллагаанд зарцуулагдах хөрөнгийг тооцоолон гаргаж, байгууллагын удирдлагад танилцуулан жилийн төсөвт тусгуулах
- Эмнэлгийн эрүүл ахуй, халдварын сэргийлэлт, хяналт, аюулгүй тарилга, хог хаягдлын менежмент, халдварт өвчинтэй тэмцэх хөтөлбөр, цусны

аюулгүй байдлыг хангах чиглэлээр гарсан тушаал заавар, журмыг хэрэгжүүлэн ажиллах

- Тусламж үйлчилгээнд шаардлагатай багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариун цэврийн бүтээгдэхүүн, эмнэлгийн ажилтны хамгаалах хувцас хэрэгслийн тооцоог гарган хангуулах арга хэмжээг төлөвлөн ажиллах
- ЭМС-ын А/539 тоот тушаалын холбогдох тандалтын хуудсаар үйлчлүүлэгчдийн дундах тандалтыг хийж, эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварын сэжигтэй тохиолдлыг зохих урсгалын дагуу мэдээлэх
- Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвар /ЭТҮХХ/-ын сэжигтэй тохиолдол илэрмэгц эх уурхайг тодорхойлох судалгааг хийж, халдварыг таслан зогсоох арга хэмжээг зохион байгуулах
- Эрүүл мэндийн ажилтны урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах, шаардлагатай тохиолдолд эмчлэх, эрүүлжүүлэх асуудлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулан хөдөлмөр зохицуулалтын асуудлыг шийдвэрлүүлэх саналыг төвийн ХСХ-ын албанд тавьж шийдвэрлүүлэх
- Эмнэлгийн ажилтан бүрийг гар угаах, халдваргүйжүүлэх, эмнэлэгт хэрэглэж байгаа ариутгал, халдваргүйтгэлийн бодисыг найруулах хэрэглэх, хувийн хамгаалах хувцас, хэрэглэлийг хэрэглэл, хурц үзүүртэй, иртэй багаж, хэрэгсэлтэй зөв харьцах, цусаар дамжих халдвараас сэргийлэх, багаж хэрэгслийг халдваргүйтгэх, угаах чиглэлээр заавар удирдамжаар хангах
- Халдвараас сэргийлэх дэглэмийн үл нийцэл, алдаа дутагдлыг бүртгэж, арилгуулах арга хэмжээг авах
- Цусаар дамжих халдвартай эрүүл мэндийн ажилтны эрүүл мэндийн байдалд жилд 2 удаа хяналт тавьж, вирусийн идэвхжилийг хянаж, халдвараас сэргийлэх арга хэмжээний заавар зөвлөгөө өгөх
- Тасаг нэгжүүдэд дадлага хийж байгаа оюутан, дадлагажигч эмч дадлага хийх хугацаанд халдварт өртөхөөс сэргийлж байгууллагын дотоод журам зааврыг танилцуулж, мөрдүүлэх
- Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэргэжлийн эрсдэлт хүчин зүйлсийг судлан тогтоож, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, халдварт өртсөн байж болох тохиолдолд эрсдэлийг үнэлэн, шаталсан арга хэмжээ хэрхэн авах талаарх мэдээллээр ажилтнуудыг бүрэн хангах
- Ажилтнуудын эрүүл мэндийн талаарх мэдээллийн нууцыг хадгалах
- Эмнэлгүүд нь үйлчлүүлж, буй иргэд халдварт өртөх эрсдэлийн үнэлгээг хийж, эрсдэлээс сэргийлэх, бууруулах арга хэмжээ авч ажиллах

- Үйлчлүүлэгч халдвар авах эрсдэлт хүчин зүйлд өртсөн тохиолдолд үйлчлүүлэгч болон түүний асран хамгаалагчид мэдэгдэж, халдвараас сэргийлэх арга хэмжээ, нарийн мэргэжлийн эмч, мэргэжилтний зөвлөгөө авах

Захирлын 2026 оны 03 сарын 21 өдрийн
4/32 тоот тушаалын 4-р хавсралт

**ХАЛДВАРЫН СЭРГИЙЛЭЛТ, ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДЭХ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖАГСААЛТ**

№	Чиглэл
1.	ХСХ-ын орон тооны бус албатай байх
2.	Орон тооны бус ХСХ-ын багтай байх
3.	ХСХ-ын асуудал хариуцсан тархвар/халдвар судлаачтай байх
4.	ХСХ-ын асуудал хариуцсан эмнэл зүйч эмчтэй байх
5.	ХСХ-ын асуудал хариуцсан халдвар хяналтын сувилагчтай байх
6.	ЭТҮХХ-ын эрсдэлийг тогтоосон байх
7.	Бичил биетний эсрэг эмэнд мэдрэг байдлыг тодорхойлох шинжилгээ хийх
8.	Бичил биетний эсрэг эмийн хэрэглээний байдлыг судалж, хянадаг байх
9.	Бичил амь судлалын лаборатори нь чанарын гадаад хяналтад хамрагдах
10.	Халдварын сэргийлэлт, хяналтын сургалт зохион байгуулдаг байх
11.	Эмэнд тэсвэртэй бичил биетний тандалт хийдэг байх
12.	Мэс заслын дараахь шархны халдвар илрүүлэх тандалт хийх
13.	Шээлгүүртэй холбоотой шээсний замын халдвар илрүүлэх тандалт хийх
14.	Зохиомол амьсгалын аппараттай холбоотой уушгины хатгаа илрүүлэх
15.	Судасны гуурстай холбоотой халдвар илрүүлэх тандалт хийх
16.	ЭТҮХХ-ыг илрүүлэх тандалтыг хийж мэдээллэдэг байх
17.	Цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийг зааврын дагуу хийдэг байх
18.	Ариутгалын тасаг, хэсэгтэй байх
19.	Ариутгалын чанарт дотоод хяналт тавьдаг, хими, физик, уурын нэвчилт, биологийн хяналт тавьдаг байх
20.	Нэг удаагийн хэрэгслийг давтан хэрэглэдэггүй байх
21.	Үйлчлүүлэгчдэд ЭТҮХХ-аас сэргийлэх мэдээлэл өгдөг байх
22.	ЭМА-ыг халдвараас сэргийлэх, хянах үйл ажиллагаанд оролцуулдаг байх
23.	Тусгаарлах өрөөтэй, сэжигтэй үйлчлүүлэгчийг тусгаарладаг байх
24.	ЭМА-ын эрүүл мэндийн байдалд хяналт тавьж үзлэг, шинжилгээнд хамруулах
25.	ЭМА-ыг халдварт өртөхөөс сэргийлэх арга хэмжээ авдаг байх
26.	ЭМА-ыг В гепатитын 3 тун вакцинаар дархлаажуулах
27.	В гепатитын дархлаа тогтоцын шинжилгээнд хамруулсан байх
28.	ЭМА бүрийг гар угаах, халдваргүйжүүлэх заавраар хангасан байх
29.	ЭМА гарын эрүүл ахуй сахилтын үнэлгээг хийж түвшинг тогтоосон байх
30.	ЭМА-ыг эмнэлэгт хэрэглэж байгаа ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодисыг найруулах, хэрэглэх заавраар хангасан байх
31.	ЭМА бүрийг хувийн хамгаалах хувцас, хэрэгсэл хэрэглэх заавраар хангах
32.	ЭМА бүрийг хурц үзүүр, иртэй багаж хэрэгсэлтэй зөв харьцах заавраар хангах
33.	ЭМА бүрийг цусаар дамжих халдвараас сэргийлэх заавраар хангасан байх

34.	Багаж хэрэгслийг зааврын дагуу цэвэрлэж, халдваргүйжүүлж, ариутгадаг байх
35.	Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэй ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодисыг үйлдвэрлэгчийн зааврын дагуу хэрэглэдэг байх
36.	Халдварын эрсдэл өндөртэй ажилбаруудыг хянах хуудсаар шалгадаг байх
37.	Эмнэлгийн мэргэжилтэн ХСХ-ын багц цагийн сургалтад хамрагдах
38.	чил биетний эсрэг эмийн зохистой хэрэглээнд хяналт тавих багтай байх
39.	Гепатитын В вирусийн халдварт өртөх эрсдэлтэй өндөртэй үйлчлүүлэгчийг (гемодиализ, дархлаа дарангуйлах эмчилгээ гэх мэт) дархлаажуулдаг байх